

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2018 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2018.12.15

№	Ажил, арга хэмжээ	Гүйцэтгэл	Хувь	Оноо
7.1. Хуулиар хүлээсэн үүргийн хүрээнд				
1	Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны 2017 оны үнэлгээний дүн, дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх, Тамгын газрын авлигын эсрэг үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөөг байгууллага, хамт олны саналд тулгуурлан боловсруулж хэрэгжүүлэх, явц үр дүнг мэдээлж тайлагнах	Иргэд, олон нийтээс төрийн байгууллага, албан хаагчдын үйл ажиллагааны талаар авсан 2017 оны санал асуулгын дүгнэлт, өмнөх жилийн тайланд хийсэн үнэлгээ, Авлигатай тэмцэх газраас өгсөн чиглэл, зөвлөмжинд тулгуурлан аймгийн Засаг даргын Тамгын газрын авлигын эсрэг үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөөг 2 бүлэг 37 ажил арга хэмжээтэйгээр боловсруулж, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан.	100	
2	Шинээр боловсруулж байгаа баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон аймгийн Засаг даргын шийдвэрийн хэрэгжилт олон нийтийн эрэлт хэрэгцээболон хуульд нийцэж байгаа эсэхийг судалж холбогдох арга хэмжээний санал боловсруулж шийдвэрлүүлэх ажлыг Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлалын 2 дахь хэсгийн шалгуурын дагуу зохион байгуулах	Захиргааны байгууллагаас гаргасан захиргааны хэм хэмжээний актад хяналт шинжилгээ, үнэлгээ хийж аймгийн Засаг даргын 2003 оны 104, 2005 оны 101 тоот захиргааны хэм хэмжээ тогтоосон актуудыг хүчингүй болгохоор холбогдох байгууллагуудаасанал дүгнэлтийг авч аймгийн Засаг даргын 2018 оны А/222, А/223 тоот захирамжуудаар хүчингүй болгон Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, хасалт хийлгэсэн. Захиргааны хэм хэмжээний актын талаар авах зарим арга хэмжээний тухай аймгийн Засаг даргын 2018 оны А/308 тоот захирамжаар захиргааны хэм хэмжээний актын судалгааг гаргаж, шаардлагатай актуудыг баталж гарган мөрдүүлэх талаар захиргааны байгууллагуудын дарга үүрэг чиглэлийг хүргүүлэн хяналт тавин ажиллаж байна.	100	
3	Сум, агентлагийн дарга нарын үр дүнгийн гэрээнд Авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх талаар тусгайлан заалт оруулж, хэрэгжилтэнд тогтмол хяналт тавьж, үр дүнг тооцох.	Аймгийн Засаг даргын 2018 онд сумдын Засаг дарга нар, агентлагийн дарга нартай хамтран ажиллах гэрээнд “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” талаарх заалтуудыг тусгасан.	100	

4	<p>Авлигын эсрэг хууль тогтоомж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилт, орон тооны бус зөвлөлийн ажлаас иргэд, байгууллага хамт олонд мэдээлэх, сурталчлах, ажлыг зохион байгуулах</p>	<p>Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 118 тоот тогтоолоор батлагдсан “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2018 оны 09 тоот “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” албан даалгаврыг гарган сум, агентлагуудад хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. 2018 онд шинээр томилогдсон 15 албан тушаалтны “ХАСУМ”-ийг хянуулж, томилон ажиллаж байна. Аймгийн Засаг даргын 2018 онд сумдын Засаг дарга нар, агентлагийн дарга нартай хамтран ажиллах гэрээнд “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” талаарх заалтуудыг тусгасан. Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн сургалтыг Алтанбулаг суманд, “Авлигагүй нийгмийн төлөөх иргэдийн оролцоо-3” төслийн хүрээнд орон нутгийн удирдлага, иргэний нийгмийн байгууллагууд, иргэдийн дунд уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. 2018 оны 4 дүгээр улиралд Байгаль, орчин аялал жуулчлалын газартай хамтран дээрх хуулиудын сургалтыг зохион байгуулахаар төлөвлөгөөгөө гарган батлуулан бэлтгэл ажлыг хангаж байна.</p>	100	
5	<p>Иргэд, байгууллагын, Авлигын эсрэг хууль тогтоомжийн болон хэрэгжилтийн мэдлэг, мэдээллийг авах нөхцөл боломжийг хангах зорилгоор аймгийн цахим хуудас, аймгийн ЗДТГ-ын улирал тутмын “Өргөн Сэлэнгэ” мэдээллийн сэтгүүлд мэдээлэл нийтлэх</p>	<p>Аймгийн болон 17 сум, 6 тосгоны албан ёсны цахим хуудсыг орчин үеийн шаардлагад нийцүүлэх зорилгоор 22.1 сая төгрөгийн хөрөнгөөр шинэчлэх ажлыг 2017 онд хийж, бүх сумд, тосгод албан ёсны цахим хуудастай болгож, админ эрхийг олгон цахим хуудасны байнгын тасралтгүй ажиллагааг ханган ажиллуулах талаар сургалт зохион байгуулж, заавар зөвлөгөө, гарын авлага өгсөн. Аймгийн албан ёсны цахим хуудсаар аймгаас зохион байгуулагдсан ажил арга хэмжээнүүдийн талаарх мэдээ, мэдээллийг тогтмол оруулж хэвшсэн бөгөөд 2017 онд 462 мэдээг, 2018 оны эхний 10 сарын байдлаар 332 мэдээ, мэдээлэл байршуулсан. Мөн байгууллагын ил тод байдлыг хангах үүднээс төсвийн болон хүний нөөцийн ил тод байдлын мэдээллүүд, хөрөнгө оруулалтын болон тендерийн зар мэдээллийг тухай бүр шинэчилэн оруулж, 2017 онд 16854 удаагийн хандалт, 2018 оны эхний 10 сард давхардсан тоогоор 15601 хандалт хийгдсэн байна. Сумдын албан ёсны цахим хуудсанд дунджаар 125000 орчим хандалт хийгдэж, мэдээ мэдээллийг ашигласан байна. Мөн техник, технологийн шинэчлэлтэй хөл нийлүүлж, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран иргэд төрийн үйлчилгээг хүртэх, төрийн байгууллага, албан тушаалтантай харилцах боломжийг нэмэгдүүлэх, хялбаршуулах зорилгоор ухаалаг утсанд зориулсан “Нээлттэй Сэлэнгэ”</p>	100	

		<p>аппликэйшнийг 2017 оны 8 дугаар сараас хэрэглээнд нэвтрүүлсэн. Аппликэйшнд аймгийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудаас үзүүлэх төрийн үйлчилгээний төрөл, бүрдүүлэх баримт бичиг, төлбөр хураамжийн талаарх мэдээллийг багтаасан “Танд үйлчилье” хэсгийг бий болгож, аймгийн цахим хуудсанд байршуулж буй мэдээ мэдээллүүд давхар байршин иргэдэд хүрч байна. Олон нийтийн сүлжээг ашиглан аймгийн Засаг даргын Тамгын газрын facebook хаягийг ажиллуулж иргэдийг мэдээллээр хангаж байна. “Аймгийн ЗДТГ” фэйсбүүкээр эхний 10 сарын байдлаар 889 мэдээллийг олон нийтэд тарааж, дунджаар 26670 хандалт хийгдсэн байна.</p> <p>Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс бэлтгэж буй хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл, сурталчилгааны www.e-khutuch.mn цахим хуудсанд байршуулах аймгийн төрийн болон төрийн үйлчилгээний байгууллагуудын мэдээллийг нэгтгэн Хууль зүйн үндэсний хүрээлэнд хүргүүлсэн. Тус цахим хуудасны туршилтын явц байдлын талаар төрийн албан хаагчид, иргэдэд таниулан сурталчлах сургалтыг 2018 оны Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газраас Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран сургалтыг зохион байгуулсан.</p>		
6	Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх хууль тогтоомж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөрийн хэрэгжилтийг зарим сум, байгууллагуудад шалгаж, зөвлөн туслах үйлчилгээг оны эхэнд гаргасан хувиараар зохион байгуулах	“Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” аймгийн Засаг даргын 2018 оны 09 тоот албан даалгаврыг гаргаж сум, агентлагуудад хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлигын эсрэг үндэсний чуулганаас гаргасан санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх, авлигын эрсдэлийн түвшинг тогтоох ажлын хүрээнд Авлигатай тэмцэх газраас гаргаж ирүүлсэн “Авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэх зөвлөмж”-ийг газар, хэлтэс, албадын дарга нарт хүргүүлж, зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга, ОНӨГ-ын дарга нарт аймгийн Засаг даргын болон хэлтсийн даргын албан тоотоор үүрэг чиглэл, зөвлөмжийг хүргүүлэн ажилласан.	100	
7	Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаатай холбогдолтой сурталчилгаа мэдээллийн хуудас, материалын түгээлт, ашиглалтыг бүртгэлжүүлэх, ашиглалтыг хянан зохицуулах ажил зохион байгуулах	Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаатай холбогдолтой сурталчилгаа мэдээллийн хуудас, материалын түгээлтийг бүртгэлжүүлж, ашиглалтанд хяналт тавьж ажиллалаа. Тайлант онд Авлигатай тэмцэх газраас “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтан нарт зориулсан” /шинэчилсэн 6 дахь хэвлэл/ гарын авлага, “Мэдүүлэг гаргагчдад	100	

		зориулсан гарын авлага”, Үндэсний хөтөлбөр, хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөө, Авлигатай тэмцэх газраас гаргадаг www.iaac.mn мэдээллийн хуудас зэргийг эрхбүхийалбантушаалтнуудад болон шинээр мэдүүлэг гаргагч нартбүртгэлээр түгээж, байгууллагын мэдээллийн самбар болон олонд хүрэх байршлуудад байршуулан ажиллалаа.		
8	Аймгийн ИТХ, аймгийн Засаг даргаас 2018 онд шинээр боловсруулж гаргахаар төлөвлөсөн бодлогын болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоол шийдвэрийн жагсаалтыг нэгтгэн аймгийн цахим хуудсаар нийтэд мэдээлэх	Захиргааны байгууллагаас гаргасан захиргааны хэм хэмжээний актад хяналт шинжилгээ, үнэлгээ хийж аймгийн Засаг даргын 2003 оны 104, 2005 оны 101 тоот захиргааны хэм хэмжээ тогтоосон актуудыг хүчингүй болгохоор холбогдох байгууллагуудаасанал дүгнэлтийг авч аймгийн Засаг даргын 2018 оны А/222, А/223 тоот захирамжуудаар хүчингүй болгон Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, хасалт хийлгэсэн. Захиргааны хэм хэмжээний актын талаар авах зарим арга хэмжээний тухай аймгийн Засаг даргын 2018 оны А/308 тоот захирамжаар захиргааны хэм хэмжээний актын судалгааг гаргаж, шаардлагатай актуудыг баталж гарган мөрдүүлэх талаар захиргааны байгууллагуудын дарга үүрэг чиглэлийг хүргүүлэн хяналт тавин ажиллаж байна.	100	
9	Дээрх жагсаалтад орсон шийдвэрийн төслүүдийг аймгийн цахим хуудсанд байршуулах, олон нийтэд танилцуулах, санал авах ажил зохион байгуулах	Аймгийн болон 17 сум, 6 тосгоны албан ёсны цахим хуудсыг орчин үеийн шаардлагад нийцүүлэх зорилгоор 22.1 сая төгрөгийн хөрөнгөөр шинэчлэх ажлыг 2017 онд хийж, бүх сумд, тосгод албан ёсны цахим хуудастай болгож, админ эрхийг олгон цахим хуудасны байнгын тасралтгүй ажиллагааг ханган ажиллуулах талаар сургалт зохион байгуулж, заавар зөвлөгөө өгсөн. Аймгийн албан ёсны цахим хуудсаар аймгаас зохион байгуулагдсан ажил арга хэмжээнүүдийн талаарх мэдээ, мэдээллийг тогтмол оруулж хэвшсэн бөгөөд байгууллагын ил тод байдлыг хангах үүднээс төсвийн болон хүний нөөцийн ил тод байдлын мэдээллүүд, хөрөнгө оруулалтын болон тендерийн зар мэдээллийг тухай бүр шинэчилэн оруулан ажиллалаа.	70	
10	Нутгийн өөрөө удирдах ёсны болон захиргааны байгууллага, хууль сахиулах, хяналт шалгалтын байгууллагуудаас зохион байгуулах төлөвлөгөөг ажлуудыг судалж нэгтгэн нийтэд мэдээлэх арга хэмжээ авах	Сум, агентлагийн дарга нарын үр дүнгийн гэрээнд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх тухай хууль, Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах заалтуудыг тусган мөрдүүлж ажилласан.	100	
11	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, төсвийн орлого, зарцуулалт, гадаадын зээл, тусламжийн хуваарилалт зардлын гүйцэтгэлийг олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулах	Шилэн дансны тухай хууль, мэдээллийн ил тод байдлыг хангуулах зорилгоор тус аймгийн 17 сумаас Алтанбулаг, Ерөө, Хүдэр, Зүүнбүрэн, Түшиг, Цагааннуур, Баруунбүрэн, Сайхан, Сант, Мандал, Баянгол, Орхон, Орхонтуул, Сүхбаатар, Шаамар зэрэг 15 суманд 1-2 удаа сургалт зохион байгуулж, газар дээр нь дадлага ажил хийлгэх,	100	

		зөвлөмж өгөх, утсаар болон цахимаар сургалт явуулж ажилласны үр дүнд шилэн дансны цахим хуудсанд мэдээ мэдээлэл байршуулалт цэгцэрлээ. Шилэн дансны тухай хууль, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах” 16 тоот тогтоолыг хэрэгжүүлэн Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харъяа 260 байгууллагын шилэн дансны цахим хуудсанд аудит хийхэд 2016 оны хэрэгжилт 82,2%-тай, 2017 онд 92.2%-тай, 2018 оны байдлаар орон нутгийн өмчит 11 байгууллага аж ахуй нэгж, төрийн чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэгч 59 байгууллага, төсвийн 190 байгууллагын мэдээлэл байршуулалт 96,8 хувьтай болж, тайлан илгээлт 100% хүрсэн нь 2016 оноос 14,6%, 2017 оноос 4.6% өссөн үзүүлэлтэд хүрч төсвийн ил тод байдал болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангагдаж байна.		
12	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь олон нийтэд мэдээлэх	Сэлэнгэ аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2017 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн Төрийн аудитын газрын дүгнэлтийг бүрэн эхээр нь Шилэн данс болон аймгийн цахим хуудсанд байршуулан олон нийтэд мэдээллэсэн.	100	
13	Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийг олон нийтэд мэдээлэх	Сэлэнгэ аймгийн 2017 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлт болон 2018 оны хагас жилийн тайлан зэргийг бүрэн эхээр нь аймгийн цахим хуудас болон Шилэн дансны цахим хуудсанд байршуулан олон нийтэд хүргээд байна.	100	
14	Тухайн жилийн төсвийн хөрөнгө оруулалт, зарцуулалтыг олон нийтэд мэдээлэх	Алтанбулаг сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 51.9 сая төгрөгөөр “Нью урбанизм” ХХК-иар гүйцэтгүүлэн ажиллаж байна. Мөн Сүхбаатар сумын 2, 6 дугаар багийн 60 айл орчмын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлыг улсын төсвийн 70.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Урбан девелопмент” ХХК гүйцэтгэж 70 хувьд хүргээд байна. 2018 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 55.0 сая төгрөгөөр Жавхлант суманд төрийн албан хаагчийн 2 айлын орон сууцны барилгыг барьж ашиглалтад оруулаад байна. Мөн Хилчдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэж, Хилийн 0101 дүгээр ангийн алба хаагчдын 14 айлын орон сууц, Хилийн 0243 дугаар ангийн хилчдийн 8 айлын орон сууцыг ашиглалтад оруулахад 55.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, цахилгаан, дулааны асуудлыг бүрэн шийдвэрлэсэн.	70	
15	Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл хөтөлбөр, хэрэгжилтийг олон нийтэд мэдээлэх	2018 онд Сүхбаатар сумын 3-р цэцэрлэгийн өргөтгөлийн ажлыг Япон улсын Засгийн газрын “Өвсний үндэс хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлсэн. Тус хөтөлбөрийн биелэлт болон холбогдох хөрөнгө оруулалтын мэдээллийг аймгийн цахим хуудас болон 3-р цэцэрлэг нь	100	

		шилэн дансны мэдээлэлд оруулж олон нийтэд хүргэсэн.		
16	Нийгмийн даатгал, халамж, хөдөлмөр эрхлэлт, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан зэргээс тэтгэвэр, тэтгэмж, зээл, тусламж авагчдыг олон нийтэд мэдээлэх	<p>Аймгийн хэмжээнд аж үйлдвэрийн тооллого явуулах ажлын хэсгийг байгуулж жижиг дунд үйлдвэрийн тоо, өрхийн үйлдвэрийн тооллогыг зохион байгуулж үр дүнг тооцлоо. Тооллогоор 531 өрх, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчид байна. Үүнд:</p> <p>Төмсхүнснийногоо өрхийн үйлдвэрлэгч – 263 Сүү, сүүнбүтээгдэхүүнболовсруулах /өрх/ – 139 Газар тариалан /өрх/ – 48 Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч - 34 Оёдол, эсгийурлалбүтээгдэхүүн -15 Мал аж ахуй, үхрийн аж ахуй – 13 Мод боловсруулах мужаан /өрх/ – 9 Барилгын материал үйлдвэр /Блок/ - 8 Жааз үйлдвэрлэл, гар урлал – 2</p> <p>Жижиг дунд үйлдвэрлэл эрхэлдэг 205 аж ахуйн нэгж байна. Үүнд:</p> <p>Газар тариалан эрхэлдэг /ААН/ – 86 Модонматериал, хавтангийнүйлдвэрлэл-40 Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл- 34 Төмс, хүнснийногоотариалалт, борлуулалт – 27 Барилгын материал үйлдвэр /блок, арматур, тоосго, эрдэс нутаг/ – 10 Оёдол, эсгий урлал – 5 Вакумцонхныүйлдвэр -3 байна.</p> <p>Аймгийн хэмжээнд үйлдвэрийн нэгдсэн тооллого явуулсны үндсэн дээр “Сум бүрт нэг үйлдвэр-үйлчилгээ” аймгийн хөтөлбөрийг боловсруулан батлуулсан. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг, боловсруулах үйлдвэрийн ангилалд багтдаг 154 аж ахуйн нэгжийн мэдээлэлийг http://industry4.nda.gov.mn/ цахим хуудсанд шивж бүртгэлжүүлсэн.</p>	100	
17	Байгууллагаас олгож байгаа тусгай зөвшөөрлийн мэдээллийг, Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлалын 5 дахь хэсгийн шалгууруудын дагуу олон нийтэд хүргэх	<p>Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах зорилгоор Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.4-т заасан шийдвэр гаргах ажиллагааны журмыг зөрчсөн, хайгуулын зөвшөөрлийг олгосноос хойш талбайд үйл ажиллагаа явуулаагүй нөхцөл байдал тогтоогдсон 5 аж ахуй нэгжийн тусгай зөвшөөрлийг аймгийн Засаг даргын 2018 оны А/289 дугаар захирамжаар хүчингүй болгож, тухайн газруудын чанар байдлын талаар дүгнэлт гаргахаар ажиллаж байна. Ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулах “Сэлэнгэ Баялаг ирээдүй” ОНӨААТҮГ-ын хувьд аймгийн Засаг даргын шийдвэрээр түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбоотойгоор үйл ажиллагаагаа явуулаагүй байна.</p>	40	

18	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах ажлыг Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлалын 6 дахь хэсгийн шалгууруудын дагуу зохион байгуулах	2018 оны Засгийн газрын “Хариуцлагын жил”, аймгийн “Хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх жил”, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн “Хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлж, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх жил”, аймгийн ЗДТГ-ын “Шинэ санал, санаачлагыг дэмжих жил”-ийн зорилтуудыг хэлтэс, тасгийн ажилтнуудын үр дүнгийн гэрээнд тусган хэрэгжүүлэн ажиллаж байна.Нутгийн захиргааны байгууллагуудын төрийн захиргааны 18 байгууллагын 43 сул орон тоог байгууллага, албан тушаал, түүнд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг бусад мэдээллийн хамт Selenge.mn, csc.gov.mn зэрэг цахим хуудсууд, ороннутгийнмэдээ, мэдээллийнхэрэгслэлээр нийтэд ил, тод зарлан нээлттэй байдлыг хангаж ажиллалаа.	100	
19	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах ажлыг Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлалын 7 дахь хэсгийн шалгууруудын дагуу зохион байгуулах	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4-т “Харьцуулалт амжилтгүй болсноос гэрээ байгуулах эрх олгоогүй бол гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэж болно” гэж заасныг үндэслэн шууд гэрээ байгуулах аргыг 14 төсөл арга хэмжээн дээр хэрэгжүүлсэн. 2018 онд 83 худалдан авалт төлөвлөсний 16,8 хувийг гэрээ шууд байгуулах аргаар зохион байгуулсан. Өмнөх оны үзүүлэлтийг харьцуулахад худалдан авах ажиллагааг 100 хувь цахим системээр явуулж байгаагийн нэг давуу тал нь ил тод нээлттэй урилга тавигдаж олон нийтэд зарлагдан бүх тендерт оролцогчийг гэрээ шууд байгуулах тендерт оролцох боломжоор хангаж ажилласан. Худалдан авах ажиллагааг 100 хувь цахим хэлбэрт шилжүүлж ажлын хэсгийн гишүүдийг доод тал нь 5-7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж мэргэжлийн байгууллагын төлөөлөл, иргэний төлөөлөлийн оролцоог 100 хувь нэмэгдүүлж ажилласан.	100	
20	Аймгийн Засаг даргаас Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллагатай тодорхой ажил, үйлчилгээг сонгон шалгаруулалтаар гүйцэтгүүлэх, хамтран ажиллах гэрээ байгуулах, үр дүнг тооцох, олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулах	Аймгийн Засаг даргаас 2018 онд аймагт идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй <i>Ахмадын хороо, Улаан загадмайн нийгэмлэг зэрэг</i> төрийн бус байгууллагатай тодорхой ажил үүргийг гүйцэтгүүлэх, хамтран ажиллах гэрээг гүйцэтгэх ажил үйлчилгээнд нь сонгон шалгаруулалт явуулах зарчмаар, байгуулан ажиллаж үйл ажиллагаанд нь гэрээний дагуу нийт 14,5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж үр дүнг улирлаар тооцон ажиллаж байна. Авлигаас урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх болон авлигын эсрэг явуулж буй төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг олон нийтэд хүргэхэд төв, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага ажилтнуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. Энэ хүрээнд тайлант онд орон нутгийн “Сэлэнгийн мэдээ”, “Шинэ гэгээ” сонин, “Миний Монгол”, “Таны Сэлэнгэ” КТВ, болон телевизийн чиглэлийн 5 чөлөөт уран		

		бүтээлчидтэй гэрээ байгуулан хамтран ажиллаж, аймгийн төсвөөс 9.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж үйл ажиллагаанд нь гэрээлсэн хөлсийг гүйцэтгэлээр тооцон олгож ажилласан.		
21	Байгууллагын ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах	Аймгийн ЗДТГ-ын Ёс зүйн хорооноос 2018 оны төлөвлөгөөг батлуулан, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2018.05.16-ны өдрийн А/34 дүгээр тушаалаар “Ёс зүйн зөрчилгүй хамт олон” аяныг аймгийн хэмжээнд өрнүүлж ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, ажлын сахилга хариуцлагыг дээшлүүлэн ажиллаж байна. Мөн аймгийн хэмжээнд ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд бүх сум, агентлагын ёс зүйн хороодод “Төрийн албаны болон мэргэжлийн ёс зүйн тухай ойлголт” сэдэвт хичээлийг хүргүүлж, заавар зөвлөмжийг тухай бүр өгч ажилласан. Аймгийн Засаг даргаас 2018 оны 9 дүгээр сард А/341, А/360 дугаар захирамжуудыг тус тус гаргаж төрийн албаны сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах тухай Засгийн газрын 258 дугаар тогтоол, болон холбогдох шийдвэрийн хэрэгжилтийг сум, хэлтэс, агентлаг, байгууллагуудад шалгах ажлыг зохион байгуулж, шалгалтаар илэрсэн зарим зөрчлийг арилгах талаар сумдад аймгийн ЗДТГ-ын даргын 2018 оны 09 сарын А/66 дугаар тушаалаар үүрэг чиглэл өгч, шалгалтын үр дүнг нэгтгэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж ажилласан. Монгол Улсын Засгийн газар, аймгийн Засаг даргаас гаргасан төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх талаарх тогтоол, шийдвэрүүдийг нэгтгэсэн “Төрийн албан хаагчийн сахилга хариуцлага” хавтсыг шинээр хийж, аймгийн Засаг даргын Тамгын газар, сум, агентлагуудад олгож, хэрэглээнд нэвтрүүлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгээд байна.	100	
22	Давхар ажил эрхэлж болох ажлын жагсаалт, судалгаа гаргаж хамт олонд танилцуулж мэдээлэх	Давхар ажил эрхэлж болох ажил, албан тушаалын судалгаагаар давхар ажил эрхлэлт бүртгэгдээгүй.	100	
23	Аймгийн Засаг дарга, Тамгын газраас гаргаж байгаа шийдвэрийн ил тод байдлыг хангах ажлыг Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлалын 13 дахь хэсгийн шалгууруудын дагуу зохион байгуулах	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нарын тогтоол, захирамж, тушаалыг тухай бүр аймгийн албан ёсны цахим хуудасны “Тогтоол шийдвэр” цэсэнд, Худалдан авах ажиллагааны талаар “Тендерийн урилга” цэсэнд байршуулж иргэд, олон нийтэд мэдээлж ажилласан.	100	
24	Иргэдийн санал өргөдөл гомдолтой холбогдсон ажил үйлчилгээг Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл	Аймгийн Засаг даргад болон ЗДТГ-т ирүүлсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэх ажлыг холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу зохион байгуулж байна. Энэ ажлын хүрээнд иргэдээс	100	

	<p>ажиллагааг үнэлэх аргачлалын 14 дэхь хэсгийн шалгууруудын дагуу зохион байгуулах</p>	<p>гаргасан өргөдөл гомдлыг бичгээр, тусгай дугаарын утсаар болон ЗГХЭГ-ын өргөдөл гомдлын программаар дамжуулан хүлээн авч байгаа бөгөөд тэдгээрийг аймгийн удирдлагуудад танилцуулан холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэн шийдвэрлэлтэнд хяналт тавин ажиллаж байна. 2018 оны эхний 3 улирлын байдлаар 10197 өргөдөл гомдол ирүүлснээс аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний газар, хэлтэс, албадад 253 өргөдөл гомдлыг шилжүүлэн шийдвэрлүүлж, хариуг холбогдох байгууллага, албан тушаалтнуудаас болон аймгийн ЗДТГ-аас хүргүүлж байна. Тайлангийн хугацаанд 9357 өргөдөл гомдлыг шийдвэрлэж, биелэлт 91.7 хувьтай дүгнэгдсэн. Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах төвөөс 2018 оны эхний 3 улирлын байдлаар Сэлэнгэ аймагт хамааралтай 50 санал шүүмжлэл ирүүснээс 45 санал шүүмжлэлийг хуулийн хугацаанд багтаан шийдвэрлэсэн бөгөөд тайлангийн хугацаанд 3 төрийн албан хаагчид сахилгын арга хэмжээ авагдсан байна. Дээрхи албан хаагчдыг ангиллаар нь авч үзвэл төрийн улс төрийн албаны 1, төрийн тусгай албаны 1, төрийн үйлчилгээний албаны 1 албан хаагч байна. Мөн холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулах, төрийн албаны ёс зүйг сахин ажиллахыг нийт төрийн албан хаагчдад үүрэг болгосон.</p> <p>Аймгийн ЗДТГ-т иргэдээс ирүүлсэн санал хүсэлтийг шийдвэрлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган аймгийн Засаг даргаар баталгаажуулж, сумдын ЗДТГ, газар, хэлтэс, албадад албан бичгийн хамт хүргүүлэн биелэлтийг авч нэгтгэх ажил хийгдэж байна. Дээрхи төлөвлөгөөнд төрийн байгууллагаас иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод болгох, төрийн албан хаагчдын ёс зүйг дээшлүүлэх, иргэдийн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд багтаан шийдвэрлэхэд анхаарч ажиллах зэрэг асуудлыг тусган оруулсан болно. Төрийн албан хаагчид болон удирдах албан тушаалтнуудын талаар иргэдээс гаргасан гомдлын мөрөөр аймгийн Төрийн албаны салбар зөвлөлийн тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгүүд аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба, Зүүнбүрэн, Сант, Хушаат сумдад ажиллан холбогдох санал дүгнэлтээ гарган тус зөвлөлийн хуралдаанд танилцуулсан байна.</p>		
25	<p>Авлигын эрсдэл, авлига гарах боломжийг бууруулах, авлига, ашиг сонирхлын зөрчилтэй ажил, асуудлыг Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлалын 15 дахь хэсгийн шалгуурын дагуу зохион байгуулах</p>	<p>“Авлига, ашигсонирхлын зөрчилгүй байгууллага, хамтолон” аян 2017 оны 10 дугаар сараас 2018 оны 10 дугаар сар хүртэл хугацаанд аймгийн Засаг даргын А/412 тоот захирамжаар өрнүүлж байна. Монгол Улсын Их Хурлын “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” 51 дүгээр тогтоол, Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний</p>	70	

		төлөвлөгөө”, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 118 тоот тогтоолоор батлагдсан “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2017 оны А/412 тоот захирамж, Авлигын эсрэг үндэсний чуулганаас гаргасан санал, зөвлөмж, Авлигатай тэмцэх газрын 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2018 оны 09 тоот албан даалгаврыг гарган нийт сум, агентлагуудад хүргүүлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллаж байна.		
26	Авлигатай тэмцэх газраас гаргасан шийдвэрийг биелүүлэх ажлыг Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлалын 16 дахь хэсгийн шалгууруудын дагуу зохион байгуулах	Авлигатай тэмцэх газраас 2018 онд нийт 14 албан бичиг, мөрдөгчийн мэдэгдэл, зөвлөмж ирүүлсэний дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллаж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж, хариуг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн ажилласан.		
7.2. Авлигатай тэмцэх санал, санаачилгын хүрээнд				
27	Аймгийн хэмжээнд мөрдөхөөр гаргасан сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагаанд үнэлгээ хийх аргачлалын дагуу үнэлгээ хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах ажил зохион байгуулах	Аймгийн Засаг даргын Тамгын газарт 2012 оноос нэвтрүүлж буй <u>Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2008, 2016 онд ISO 9001:2015</u> шинэ стандартын хэрэгжилтийг мөрдөж гаргасан дүгнэлт зөвлөмжийн дагуу хийх ажлаа төлөвлөн хэрэгжүүлж, түүндээ дотоод аудитийн баг томилон ажиллуулж үр дүнгээ хамт олноороо хэлэлцэх арга хэмжээ аван ажиллаж байна.	100	
28	Төрийн албан хаагчдын ХАСХОМ болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдүүлэлт, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх сургалт зохион байгуулах, зөвлөмж боловсруулан сум, агентлагт хүргүүлж, хэрэгжилтийг хангуулж ажиллах	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд ХАСХОМэдүүлэг гаргах албан тушаалтнуудын 2017 оны ХАСХОМэдүүлгийг жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргах хуулийн хэрэгжилтийг хангаж мэдүүлэг гаргагч нарын ХАСХОМ-ийг хүлээн авч бүртгэн тайланг Авлигатай тэмцэх газрын Хяналт, шалгалт, дүн шинжилгээний хэлтэст хүргүүллээ. Мөн шинээр нийтийн албанд томилогдож буй албан тушаалтнуудын хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах үйл ажиллагаанд байнгын хяналт тавин ажиллаж, зөвлөгөө, дэмжлэг үзүүлж байна.	100	
29	Хяналт, шалгалтын мөрөөр авсан арга хэмжээний дүнг мэдээлэх, ил тод болгох, зөрчил илэрсэн тохиолдолд хуульд заасан хариуцлагын талаар зөвлөмж боловсруулан сум, агентлагт хүргүүлж, хэрэгжилтийг хангуулж ажиллах	Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн албан тоотын дагуу Зөвлөх үйлчилгээний “Эс Ай Си Эй” компаниар гүйцэтгүүлэх судалгаанд аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны албан хаагчид, тамгын газраар үйлчлүүлсэн иргэдийг болон Сүхбаатар, Шаамар, Алтанбулаг сумд, зарим агентлагуудыг судалгаанд хамруулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Мөн Авлигатай тэмцэх газрын 2018 оны 04 дүгээр сарын 30-	100	

		ны өдрийн авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга, ОНӨГ-ын дарга нарт аймгийн Засаг даргын болон хэлтсийн даргын албан тоотоор үүрэг чиглэл, зөвлөмжийг хүргүүлэн ажилласан.		
30	Нутгийн захиргааны байгууллага, төрийн албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээнд иргэд олон нийтийн саналыг авч ажиллах	Сум, агентлагийн дарга нарын үр дүнгийн гэрээнд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх тухай хууль, Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах заалтуудыг мөрдөж ажиллах талаар оруулсан.	100	
31	Авлигаасурьдчилансэргийлэхүйлажиллагаандиргэдийноролцоогнэмэгдүүлж, аймаг, сумынгэмтхэргээсурьдчилансэргийлэхзөвлөлийндэргэд “Иргэнийхяналтынзөвлөл”-ийгбайгуулах ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцож, тайлагнах	Авлигатай тэмцэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.7, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.4.15 дахь зорилтуудын хэрэгжилтийг хангах, авлигаас урьдчилан сэргийлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэд байгуулагдсан “Иргэдийн хяналтын зөвлөл”-ийн гишүүдэд Авлигатай тэмцэх газартай хамтран сургалтанд хамруулан, чадавхижуулах ажлыг зохион байгуулж, хууль тогтоомжийн хүрээнд ажиллаж байна. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр шинэчлэн байгуулж, иргэдийн хяналтын зөвлөлийн гишүүд нутгийн захиргааны 3 дугаар байранд байрлан гэрээний үүргээ биелүүлэн ажиллаж байна. Авлигатай тэмцэх газрын даргын тушаалаар Авлигатай тэмцэх газрын ажлын хэсэг 2018 оны 22-24-ний өдрүүдэд орон нутагт ажиллан тус зөвлөлийн гэрээг дахин шинэчлэн байгуулсан.	100	
32	“Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж, үр дүн тайлан мэдээг хүргүүлэх.	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 118 дугаар тогтоолоор 9 бүлэг, 5 зорилт бүхий “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөр”-ийг батлуулан хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар сум, агентлаг, холбогдох байгууллагуудад чиглэл хүргүүлэн ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд “Авлига, ашиг сонирхлын зөрчилгүй байгууллага, хамт олон” аян болон хяналт шалгалтын удирдамжийг аймгийн Засаг даргын 2017 оны А/412 дугаар захирамжаар “Авлига, ашигсонирхлынзөрчилгүйбайгууллага, хамт олон” аяныг 2017 оны 10 дугаарсараас 2018 оны 10 дугаарсархүртэлхугацаандөрнүүлэх ажлыг зохион байгуулсан. Дээрх хугацаанд аяны хүрээнд хийсэн ажлын тайланг сум, агентлагуудаас татан авч нэгтгэх ажлын эхлүүлээд байна.	100	
33	Авлигатай тэмцэх газраас явуулсан Төрийн байгууллагын 2017 оны авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлсэн үнэлгээ дүгнэлтээр илэрсэн зөрчил дутагдлыг	Монгол Улсын Засгийн газраас 2018 оныг “Хариуцлагын жил” болгон зарласантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны 05, 2017 оны 06, 2018 оны 09 тоот албан даалгавруудын хэрэгжилийг эрчимжүүлж, төрийн албаны ёс зүй, сахилга хариуцлагын талаар		

	залруулах зөвлөмжийг хэрэгжүүлэх ажил зохион байгуулах	зөрчил дутагдалгүй ажиллах, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулан ажилласан. Авлигын эсрэг үндэсний чуулганаас гаргасан санал, зөвлөмж, Авлигатай тэмцэх газрын 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2018 оны 09 тоот албан даалгаврыг гарган нийт сум, агентлагуудад хүргүүлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллан, эцсийн байдлаар тайлагнахаар сумд, агентлагуудаас татан авч нэгтгэх ажлыг эхлүүлээд байна.		
34	Авлигын эсрэг олон нийтийн ёс зүй, ухамсар сэтгэлгээг өөрчлөх сургалтыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, сургалт, сурталчилгаа явуулах хүний нөөцийг бүрдүүлэх бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх	Авлигатай тэмцэх газартай хамтран эрх бүхий албан тушаалтнууд болон ХАСХОМ гаргах үүрэг бүхий ажилтнууд, мэдүүлэг гаргагч нарт зориулсан сургалтыг 2018 оны 01 дүгээр сарын 22-23-ны өдрүүдэд аймгийн төвд зохион байгууллаа. 2018 оны 10 дугаар сард Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын нийт алба хаагчдад Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэхээ мэдэгдэх, тайлбарлах тухай сэдэвт сургалтыг зохион байгуулсан. 2018 оны 4 дүгээр улиралд Байгаль, орчин аялал жуулчлалын газартай хамтран дээрх хуулиудын сургалтыг зохион байгуулахаар төлөвлөгөөгөө гарган батлуулан бэлтгэл ажлыг хангаж байна.	70	
35	“Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх” чиглэлээр олон нийтэд хүртээмжтэй, оролцоог хангасан шударга ёсны аян зохион байгуулах	Нийтийналбанднийтийнболонхувийнашигсонирхлыгзохицуулах, ашигсонирхлынзөрчлөөсурьдчилансэргийлэхтухайхууль, ТөрийналбанытухайхуулиудынхолбогдохзаалтуудболонТөрийн албатай холбоотой хууль тогтоомж,Төрийналбанызөвлөлийнсалбарзөвлөлийнажиллахжурмыгүй лажиллагааныхааудирдлагаболгонтайлантоныхоозорилго, зорилтынхэрэгжилтийг хангах, орон нутгийн хүний нөөцийн чадавхийг хөгжүүлэх, стандартын удирдлагаар ханган мэргэшил арга зүй, бодлогын дэмжлэг үзүүлэх, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог нэвтрүүлэхэдголүйлажиллагаагаачиглүүлэнтөлөвлөсөнажиларгахэмжэ эгамжилттайхэрэгжүүлэнажиллалаа. 2018 оныжилийн эцсийнбайдлааршинээртомилгоохийхбүртээхувийнашигсонирхлынурь дчилсанмэдүүлгийгхянуулантомилгоогоохийхжэвшсэн. 2018 онд 15албантушаалтнхувийнашигсонирхлынурьдчилсанмэдүүлгийгавлига тайтэмцэхгазартхүргүүлэнхянуулсан. Мөн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, ажлын сахилга хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор “Ёс зүйн зөрчилгүй хамт олон” аяныг аймгийн хэмжээнд 2018 оны 05 дугаар сарын 15-наас 07 дугаар сарын 02-ны өдөр хүртэл зохион байгуулахаар аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны А/34 тоот тушаал гаран хэрэгжилтийг хангуулан ажиллаж	100	

		байна.АвлигынэсрэгхуульболонНийтийналбанднийтийнболонхувийнаш игсонирхлыгзохицуулах, ашигсонирхлынзөрчлөөсурьдчилансэргийлэхтухайхуулийнсургалтыгАл танбулагсуманд, “Авлигагүйнийгмийнтөлөөхиргэдийн оролцоо-3” төслийнхүрээндороннутгийнудирдлага, иргэнийнийгмийнбайгууллагууд, иргэдийндундуулзалт, хэлэлцүүлгийгзохионбайгуулсан.		
36	Төрийн бодлого боловсруулах, хэлэлцэх, батлах зэрэг шийдвэр гаргах бүх шатанд тухайн асуудлаар үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагын иргэдийг татан оролцуулах	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2018 оны 09 тоот албан даалгаврыг гарган нийт сум, агентлагуудад хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх тухай аймгийн Засаг даргын зөвлөлийн гишүүдээр мэдэгдэл, тайлбарыг гаргуулан аймгийн шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг шивж оруулсан.	100	
37	Хэвлэл мэдээллийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулж, хууль, хөтөлбөр сурталчилсан нэвтрүүлэг, ярилцлага зохион байгуулах	Авлигаас урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх болон авлигын эсрэг явуулж буй төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг олон нийтэд хүргэхэд төв, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага ажилтнуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. Энэ хүрээнд тайлант онд орон нутгийн “Миний Монгол”, “Таны Сэлэнгэ” КТВ-ээрАвлигатай тэмцэх газрын ажлын хэсэг2018 оны 11 дүгээр сарын 22-24-ний өдрүүдэд орон нутагт ажилласан талаарх нэвтрүүлэг, ярилцлагыг зохион байгуулан ажилласан.	100	
	Нийт -37			95.1

Тайланг нэгтгэн боловсруулсан:

Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Д. Ёндонжамц

Авлигын эсрэг хууль тогтоомж, хүний эрхийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн,
Эрх бүхий албан тушаалтан

Л.Баярсүрэн

Хянасан:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Ө.Сувдаа